



**МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН
ТУШААЛ**

2025 оны 10 сарын 31 өдөр

Дугаар A/456

Улаанбаатар хот

Арилжаанд оролцох эрхийг сэргээх тухай

Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.1.9, "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн Дүрмийн 6 дугаар зүйлийн 6.9.3, "Гишүүнчлэлийн журам"-ын 7 дугаар зүйлийн 7.2.1 дэх заалтууд болон "Ди эйч капитал ҮЦК" ХХК-ийн 2025 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн 40 тоот албан хүсэлтийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн Гүйцэтгэх захирлын 2025 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн А/416 дугаар тушаалаар арилжаанд оролцох эрхийг нь түдгэлзүүлсэн "Ди эйч капитал ҮЦК" ХХК нь гаргасан зөрчлөө арилгаж, үйлчилгээний хөлсөө төлсөн тул арилжаанд оролцох эрхийг 2025 оны 11 дүгээр сарын 3-ны өдрөөс эхлэн сэргээсүгэй.
2. "Ди эйч капитал ҮЦК" ХХК-ийн үнэт цаасны арилжааны программд нэвтрэх нэр, нууц үгийг сэргээхийг Үйл ажиллагааны газар (И.Жавхлан)-т үүрэг болгосугай.
3. Монгол Улсын үнэт цаасны зах зээлд мөрдөгдөж буй хууль тогтоомж, дүрэм, журам, заавар болон "Гишүүнчлэлийн гэрээ"-ээр хүлээсэн үүргээ тогтмол биелүүлж ажиллахыг "Ди эйч капитал ҮЦК" ХХК (М.Бат-Оргил)-д даалгасугай.
4. Гүйцэтгэх захирлын 2025 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн А/416 дугаар тушаалын "Ди эйч капитал ҮЦК" ХХК-д хамаарагдах хэсгийг 2025 оны 11 дүгээр сарын 3-ны өдрөөс эхлэн хүчингүй болгосугай.
5. Тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт зохицуулалтын газар (А.Мөнхбаясгалан)-т, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод хяналтын албаны мэргэжилтэн Ч.Эрдэнэболорт тус тус даалгасугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Т.ХАШ-ЭРДЭНЭ

1525030354